



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь салбарын хууль тогтоомж, түүний үзэл баримтлал, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын чиглэлээр иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулах, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд дараах үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2. Мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, усан хангамжийг сайжруулах, малыг байгаль, цаг агаарын эрсдэлээс хамгаалах, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, малчдын орлого нэмэгдүүлэх, малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, малын үржил, селект, генетик нөөцтэй холбоотой бодлого, стратегийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, малын генетик нөөцийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах;

3. Газар тариалангийн үйлдвэрлэлийн байгаль, цаг агаарын эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, үр, сортын шинэчлэл, хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, таримал ургамлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн тогтвортой, хүртээмжтэй хангамжийг бий болгох тариалангийн үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй техник, технологи нэвтрүүлэн тогтвортой хөгжлийг хангах;

4. Хүнс болон хоол үйлдвэрлэлд кластерын сүлжээг хөгжүүлэх, хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, импортыг орлох, экспортлох боломжийг нэмэгдүүлэх, аймгийн хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, бэхжүүлэх, мэдээллийн цахим санд мэдээлэх

5. Хөнгөн үйлдвэрийн салбарт бодлогын хэрэгжилтийг хангаж, экспортын баримжаатай болон импортыг орлох бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, кластерын сүлжээг хөгжүүлэх, хөнгөн үйлдвэрийн инноваци, технологийн шинэтгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах;

6. Ахуйн үйлчилгээний салбарын хөгжлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах;

7. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын хөгжлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах

8. Хоршооны салбарын хөгжлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах;

9. Жил бүр төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах, хүн амыг аюулгүй хүнсээр хангах сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;